



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.04.20. № 03/861

танай _____-ны № _____-т


**Хяналт шалгалтын ажлын
дүгнэлт зөвлөмж хүргүүлэх тухай**

Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж дүгнэлт, зөвлөмж гарсныг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллаж, 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор хэрэгжилтийн талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Хавсралт. // хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА



Б.БАТЦЭЦЭГ

1523032600

**И-МОНГОЛ АКАДЕМИ УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД 2022 ОН, 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2023.04.20

№

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт шалгалтын
зорилго**

Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд заасан яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үнэлэх, дүгнэх арга хэмжээний хүрээнд “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газарт хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, удирдамжийг баталсан.

Уг хяналт шалгалтын зорилго нь “И-Монгол академи” УТҮГ-ын 2022он, 2023 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаанд хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид үүсэж болзошгүй аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хяналт-шалгалтыг хийхдээ Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгосон болно.

Ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд УТҮГ-ын байранд 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр байрлаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас өгсөн чиглэлийн хэрэгжилт, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулсан болон албан хаагчдаас гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хүний нөөцийн чиглэлээр 2022-2023 онд гаргасан захирлын тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэл, баримт бичгийн боловсруулалт, албан хэрэг хөтлөлт, архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалттай танилцлаа.

**Хоёр.Хяналт шалгалтын ажлын зохион
байгуулалт**

Ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорол ахалж, Ажлын хэсгийн гишүүнээр Төрийн захиргааны удирдлагын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Солонго, тус хэлтсийн мэргэжилтэн Б.Ану-Үжин, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Г.Дэлгэрмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Г.Эрдэнэцэцэг, Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн А.Түвшинзаяа нар ажиллалаа.

Хяналт шалгалтыг байгууллагын баримт бичгийг хянан үзэх, хяналт шалгалтын явцын үр дүнг зургаар баримтжуулах, тайлбар, мэдээлэл судалгаа, холбогдох баримт бичгийг гаргуулан авах, хуульд заасан бусад арга хэлбэрээр тухайн газарт хянаж үлдэх баримт болон тодруулах асуудлыг цахим хэлбэрээр хүлээн авч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан болно.

Гурав.Хяналт, шалгалтын талаар /илэрсэн зөрчил/


1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас өгсөн чиглэлийн хэрэгжилт

Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2022 онд 39, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 31 албан бичгээр сервис хөгжүүлэх, систем хөгжүүлэх, систем хүлээж авах чиглэлийг хүргүүлснээс 2022 онд хүргүүлсэн чиглэлийн хэрэгжилт хангалттай гэж дүгнэсэн.

Тус яам 2023 онд “И-Монгол академи” УТУГ-т сервис хөгжүүлэх, систем хөгжүүлэх, систем хүлээж авах, сургалт зохион байгуулах, дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд холбох, нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө мэдээлэл хариуцагчид өгсөн дүгнэлт, зөвлөмж өгөх, албан бичиг солилцооны дундын системд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон lawlagaa.emongolia.mn системээр гарах лавлагаа тодорхойлолтыг үнэгүй болгох зэрэг утга агуулгатай хүргүүлсэн чиглэлээс 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар шийдвэрлэсэн 20, судлагдаж байгаа 11 албан бичиг байна.

Тус яамнаас 2023 оны 1 дүгээр улиралын байдлаар дараах агуулга бүхий чиглэлийг хүргүүлсэн бөгөөд диаграммд чиглэлийг хувиар үзүүлэв:

- сервис хөгжүүлэх;
- систем хөгжүүлэх;
- систем хүлээж авах;
- сургалт зохион байгуулах;
- дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд холбох;
- албан бичиг солилцооны дундын системд холбох;
- нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө мэдээлэл хариуцагчид өгсөн дүгнэлт, зөвлөмж өгөх;
- Цахим лавлагааны lawlagaa.emongolia.mn систем болон Төрийн нэгдсэн үйлчилгээний систем И-Монгол платформаар гарах лавлагаа тодорхойлолтыг үнэгүй болгох.



Тус яамнаас өгсөн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг дурдвал:

Сервис хөгжүүлэх чиглэлийн хүрээнд: 2023 онд Төрийн мэдээлэл солилцооны үндсэн “ХУР” системд Хил хамгаалах ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу 2 сервисийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байна.

Систем хөгжүүлэх чиглэлийн хүрээнд:

- хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдсан эсэхийг шалгаж “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн мэдээллийг иргэнд харуулах боломжийг бүрдүүлэх
- <https://e-tanhim.gov.mn/> нэвтрүүлэх
- Боомтын сэргэлтийн үндэсний хорооны цахим хуудсыг хөгжүүлэх
- Танилт, нэвтрэлтийн системийн хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна.

Систем хүлээж авах чиглэлийн хүрээнд: Төрийн судалгааны нэгдсэн систем /<https://sudalгаа.gov.mn/>-ийг Шинжлэх Ухаан технологийн их сургуулиас, хяналт шалгалтын систем /<http://www.shilenhyanalt.gov.mn/>, цахим үйлчилгээний систем /<http://www.igov.gov.mn/>, хяналт шалгалт төлөвлөлт, бүртгэлийн систем /<http://www.e-khyanalt.gov.mn/>, үйлдвэрлийн осол, хурц хордлогын бүртгэлийн систем <http://www.om.inspection.gov.mn/>, аюултай хог хаягдлын бүртгэл хяналтын систем /www.khog-khyanalt.mn/-ийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах үүрэг бүхий комиссоос хүлээж авахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Сургалт зохион байгуулах ажлын хүрээнд: “И-Монгол академи” УТҮГ нь 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар дараах сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд:

-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу дотоод удирдлагын нэгдсэн болон албан бичиг солилцооны дундын системийн ашиглалттай холбоотой сургалт,

-Цахим ур чадвараа дээшлүүлэх сургалт /26 удаагийн 54 цагийн сургалтыг нийт 1439 иргэнд танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулсан ба шинээр сургалтад хамрагдсан иргэдийн цахим ур чадварын түвшин 55 хувьтай байсан бол сургалтын дараа 83 хувьтай болж нэмэгдсэн/

Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд холбох чиглэлийн хүрээнд: 2022 онд 2100, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 86 байгууллагыг холбосон байна.

Албан бичиг солилцооны дундын системд холбох чиглэлийн хүрээнд: 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар төрийн 463 байгууллагыг холбосон байна.

Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө мэдээлэл хариуцагчид өгсөн дүгнэлт, зөвлөмж өгөх чиглэлийн хүрээнд 2022-2023 онд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг автоматжуулах систем, Соёлын яамны “Цахим соёл” арга хэмжээг нэвтрүүлэх веб портал, “G.L.A.M” систем болон уран бүтээл, урын сангийн бүртгэлийн цахим нэгдсэн сан, Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим сан, Номын сангийн программ, Архангай аймгийн Засаг даргын Тамгын газраас “Дижитал Архангай” төсөл, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын худалдан авах үйл ажиллагаанд цахим системүүдийн интеграци хийхэд дүгнэлт, зөвлөмжийг өгсөн байна.

Цахим лавлагааны lawлагаа.e-mongolia.mn систем болон Төрийн нэгдсэн үйлчилгээний систем И-Монгол платформаар гарах лавлагаа тодорхойлолтыг үнэгүй болгох чиглэлийн хүрээнд: Тус яамнаас Боловсрол, шинжлэх ухааны яам, Зам, тээвэр хөгжлийн яаманд хамаарах цахим лавлагаа /lavлагаа.e-mongolia.mn/-г үнэгүй болгох асуудлаар харилцан зөвшилцөж, автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа, автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа, бүрэн дунд

боловсролын гэрчилгээний лавлагаа, суурь боловсролын гэрчилгээний лавлагаа, дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт, лавлагаа зэргийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс үнэ төлбөргүй олгож байна.

Системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах чиглэлийн хүрээнд:

Дэмжих системийн хэвийн найдвартай ажиллагаа, ачаалал даах чадварыг сайжруулахын тулд системийн бүтцийн түвшинд кластер зохион байгуулалттайгаар дахин загварчилсан. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-mongolia-ийн dns-cache шийдэл нэвтрүүлсэн.

Дараах системүүдийн тасалдлыг хянах хяналтын системийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна:

- Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем /ХУР/;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/;
- Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн систем /service.e-mongolia.mn/;
- Төрийн үйлчилгээний операторын систем /operator.e-mongolia.mn/;
- Төрийн үйлчилгээний нөхцөл шаардлагын систем /manage.e-mongolia.mn/;
- Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp.e-mongolia.mn/;
- Албан бичиг солилцооны дундын систем /docx.gov.mn/;
- Мэдэгдэл хүргэх систем;
- Нээлттэй өгөгдлийн /opendata.gov.mn/;
- Цахим лавлагааны нэгдсэн систем /lavlagaa.e-mongolia.mn/;
- Засгийн газрын хуралдааны систем /e-cabinet.mn, e-business.mn, sudalгаа.mn/.

Илэрсэн зөрчил:

“И-Монгол академи” УТҮГ нь систем хөгжүүлж, сургалт зохион байгуулж, системийн тасралтгүй найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа боловч, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас бичгээр өгсөн чиглэлийн хэрэгжилтийг эргэж мэдэгддэггүй, хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж байгаа талаар явцын мэдээлэл өгдөггүй зэрэг асуудлууд байна.

Чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хариуцан ажиллаж байгаа системийн саатал, тасалдал, гарсан зөрчил түүний шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээллийг тус яаманд ирүүлдэггүй;


Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд албан бичгийн шийдвэрлэлтийг хангалтгүй хаадаг /Жишээлбэл Тус яамнаас ИМА УТҮГ-т 2023 оны 01 дүгээр сарын 27 өдөр хүргүүлсэн 06/196 дугаар бүхий албан бичгийг “холбогдох хүмүүстэй уулзаж хамтын ажиллагааг эхлүүлсэн” гэж хаасан боловч Байгаль орчны газраас дахин 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06/666 дугаар бүхий албан бичгээр дээр дурдсан бичигтэй холбоотой арга хэмжээ хийгдээгүй талаар мэдээлэл ирсэн/;

Мөн “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын дагуу Үндсэн болон дэмжих системтэй холбоотой тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдөрт багтаан ирүүлдэггүй алдаа зөрчлүүд ажиглагдаж байна.

2.Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулсан болон албан хаагчдаас гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

“И-Монгол академи” УТҮГ нь Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн 2 дугаар шугам, байгууллагын цахим хуудсаар болон system@ema.gov.mn, info@ema.gov.mn, e-mongolia@ema.gov.mn цахим шуудангийн хаягаар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн 2 дугаар шугамаар дамжуулан 2022 онд 2244 өргөдөл, гомдол, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 766 өргөдөл, гомдол ирүүлснийг Иргэдээс, төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хугацааг баримтлан шийдвэрлэсэн байна.



Нийт 2022-2023 онд бүртгэгдсэн өргөдөл, гомдлын 88 хувь нь Улсын бүртгэлийн ерөнхий газартай холбоотой буюу гадаад паспорт, иргэний үнэмлэх, шилжилт хөдөлгөөтэй холбоотой, 7 хувь нь бусад байгууллагуудаас шилжиж ирсэн асуудал, 5 хувь нь Цагдаагийн ерөнхий газрын бүртгэл хяналтын төвтэй холбоотой буюу жолооны үнэмлэх, төлбөрийн буцаан олголттой холбоотой гомдлууд тус тус эзэлж байна.

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн 2 дугаар шугамаар Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг улсын хэмжээнд нийт 5 оператор ажлын 8 цагийн горимоор ажиллан хүлээн авч байгаа ба 2022 онд 149814 дуудлага ирснээс 110637 дуудлаганд хариулж, 74 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Мөн байгууллагын албан хаагчдаас 2022 онд 45 өргөдөл бүртгэгдсэн нь ажлаас чөлөөлөгдөх, чөлөө хүсэх, буцалтгүй тусламж хүссэн агуулгатай байсан бөгөөд өргөдөлд дурдагдсан бүхий л асуудлыг захирлын тушаалаар шийдвэрлэсэн байна.

Илэрсэн зөрчил:

Тус байгууллага нь өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт өргөдөл гомдлыг хэзээ, хэрхэн шийдвэрлэсэн, хариуг эзэнд нь ямар журмаар мэдэгдсэн зэргийг дутуу хөтөлсөн, бичгээр гаргасан нийт өргөдөл, гомдлууд бүгд албан хаагчдаас ирүүлсэн байх ба өөр бусад чиглэлээр ирүүлсэн өргөдөл, гомдлуудаа бүртгэж байгаа эсэх нь баримт материалаас харагдахгүй, тодорхойгүй байна.

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн 2 дугаар шугамын тусгай дугаарт ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийг хянахад гомдол гаргаж байгаа иргэний дуудлагыг хадгалж системд оруулаагүй, гомдлын агуулгыг бүрэн шивж оруулдаггүй, 11-11 төв руу буцааж байгаа болон бусад байгууллага руу шилжүүлж байгаа өргөдөл, гомдлын тайлбар, шилжүүлгийн утга агуулга ойлгомжгүй байна.

Мөн 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 11-11-ийн 2 дугаар шугамын тусгай дугаарт холбогдож, хяналт тавьж үзэхэд операторууд “Иргэд, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааны журам”-ын зургаа дугаар хэсэгт заасан Үйлчилгээний стандартыг бүрэн гүйцэт мөрдлөг болгон ажиллаж хэвшээгүй зөрчлүүд илэрч байна.

3.Хүний нөөцийн чиглэлээр 2022-2023 онд гаргасан захирлын тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, боловсруулалт

Хүний нөөцтэй холбоотой Б тушаал 2022 онд 191, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 42, үйл ажиллагаатай холбоотой гарсан А тушаал 2022 онд 99, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 16 бүртгэгдэж, байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм журмыг дараах тушаалуудаар баталсан байна. Үүнд:

-Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай” А/030 дугаар тушаал;

-2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн “Иргэд, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааны журам батлах тухай” А/60 дугаар тушаал;

-2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комисс байгуулах тухай” А/90 дүгээр тушаал;

-2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Систем хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, хэвийн найдвартай ажиллагааг хангах журам батлах тухай” А/93 дугаар тушаал.

Тушаалын үндэслэх болон захирамжлах хэсэгт гарсан зөрчлүүд:

Захирамжлалын баримт бичгийн үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичнэ.

• Ажилтныг ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой тушаалын үндэслэх хэсэгт “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/65 дугаар тушаал, “И-Монгол академи” УТҮГ-ын захирлын 2022 оны А/83 дугаар тушаал”-ыг үндэслэжээ. Эдгээр шийдвэр нь ямар агуулгатай, аль заалтаар дээрх харилцааг зохицуулсан, эрх олгосон шийдвэр мөн эсэх нь тодорхой бус байна. Тухайлбал, “А.Болорыг ажилд томилох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр, “Б.Мөнхтулгыг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Б/19 дүгээр тушаал г.м;

• “Б.Мөнхтулгыг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Б/19 дүгээр тушаалын үндэслэх хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт”-ыг үндэслэжээ. Гэтэл уг заалтаар ажилтныг чөлөөлөх бус “10/ эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;” эрхийг олгосон;

• Баримт бичгийг боловсруулсан, хянасан, хэвлэмэл хуудаас буулгасан албан хаагчид ажилдаа хайнга хандаж найруулгын болон үг үсгийн алдаа гаргасан нь тушаалын агуулгыг ойлгомжгүй болгож байна. Тухайлбал, “Б.Баянбилэгт жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/05

дугаар тушаалын үндэслэх хэсэгт “Засгийн газрын 1944 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам” гэж эрх зүйн баримт бичгийн батлагдсан огноог буруу бичсэн, тус журмын эрх олгогдсон заалтыг дурдаагүй, тушаалын 3 дахь заалтад нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын “шимтгэлийг” гэсэн үгийг орхигдуулсан;

- “Б.Үнэнбатыг дагалднаар ажиллуулах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/06 дугаар тушаалын үндэслэх хэсэгт “И-Монгол академи УТҮГ-ын дүрмийн 5.2.11 дэх заалт” үндэслэсэн ч дүрэмд ийм дугаарлалттай заалт байхгүй, Хөдөлмөрийн дотоод журамд дээрх агуулга бүхий зохицуулалт байгаа бөгөөд боловсруулсан болон хэвлэмэл хуудаст буулгасан албан хаагч хайнга хандаж алдаа гаргасан;

- “Б.Хишигжаргалыг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/09 дүгээр тушаалд захирамжлах хэсгийн найруулга алдаатай, процесс аналит албан тушаал аль газрын албан тушаал гэдгийг бичээгүй, ажил үүргийг хүлээн авах, хүлээлцэх процессыг заагаагүй, Хөдөлмөрийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.8 дахь заалтыг үндэслэлд оруулснаар ажилтантай байгуулсан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг бүрэн дуусгавар болгохоор байна;

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 283 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 1.2-т “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газар (цаашид “И-Монгол академи” гэх) нь” гэж, 1.4-т “Оноосон бүтэн нэр нь “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газар байх бөгөөд товчилсон нэр нь “И-Монгол академи” УТҮГ байна” гэж тус тус тодорхойлж, “И-Монгол академи”, “И-Монгол академи” УТҮГ гэх товчлолыг хэрэглэхээр заасан ч бүх тушаалд “тус газрын” гэх товчлолыг хэрэглэсэн байна;

- “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.4.7-д “тухайн хүний эцэг (эх)-ийн нэрэнд харьяалахын тийн ялгалын нөхцөлийг залгаж бичих,” гэж заасан ч бүх тушаалд “... овогтой ...” гэж бичсэн. “Цэцгээ овогтой Батаа” гэснийг “Цэцгээгийн Батаа” гэж бичээгүй;

- “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 3.2.9-д “Захирамжлалын нэг баримт бичгээр тодорхой нэг асуудлыг шийдвэрлэнэ.” гэж заасан. Гэтэл “Зарим албан хаагчдыг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн Б/28 дугаар тушаалд томилогдсон болон чөлөөлөгдсөн ажилтны нэр, албан тушаал нь тодорхойгүй, эсхүл албан тушаалын чиг үүрэг өөрчлөгдөж байгаа эсэх нь ойлгомжгүй;

- Ажилтнаас гаргасан өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж байгаа бүх тушаалд тухайн гаргасан өргөдөл, хүсэлтийн агуулгыг дурдаагүй байна. Тухайлбал, “Т.Ундралд цалингүй чөлөө олгох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/03 дугаар тушаалд “Төмөрлэн овогтой Ундралын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр гаргасан хүсэлт”, “Зарим албан хаагчдыг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн Б/28 дугаар тушаалд “Нийтийн мэдээллийн системийн газрын дарга С.Мягмарсүрэнгийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн гаргасан хүсэлтийг үндэслэн” гэж дурдахдаа хүсэлтийн агуулгыг тодруулаагүй;

- Хөдөлмөрийн гэрээтэй албан хаагчийн ажлын байрыг ажил олгогч хадгалах үүрэгтэй бөгөөд ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд томилох ажилтны хөдөлмөрийн гэрээний хугацааг үйл явдлаар буюу эзгүй байгаа ажилтныг ажилдаа

эргэж орох хүртэл хугацаагаар заахаас бус түүний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр гэсэн агуулгаар томилохгүй. Тухайлбал, “Г.Үүрийнтуяаг түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай” 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Б/12 дугаар тушаал;

- Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт “Ажил олгогч ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай шийдвэртээ ажил хүлээлгэн өгөх хугацааг заана” гэж заасан ч ажлаас чөлөөлөх, чиг үүрэг өөрчлөх агуулгатай тушаалуудад ажил хүлээлгэн өгөх хугацааг заагаагүй;

- “Цалинтай чөлөө олгох тухай” 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/109 дүгээр тушаалын 2 дахь заалтад “Г.Батдэлгэрт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10 өдрийн цалинтай чөлөө олгохыг ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.” гэж заасан нь агуулгын хувьд алдаатай буюу ерөнхий нягтлан бодогчид захирлаас чөлөө олгох эрхийг шилжүүлсэн гэж ойлгогдохоор байна. Өөрөөр хэлбэл “Г.Батдэлгэрийн чөлөөтэй байх хугацаанд цалин хөлсийг хэвээр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.” гэж заахаар байна;

- “Ажил хавсарган гүйцэтгүүлэх тушаал хүчингүй болгох тухай” 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/130 дугаар тушаалын 1 дэх заалтаар “...В.Лут-Очирын өөрийн хүсэлтийг үндэслэн түүний хавсарган гүйцэтгэж байсан Шалгалт хариуцсан мэргэжилтэн албан тушаалаас чөлөөлж, “И-Монгол академи” УТҮГ-ын захирлын “Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” Б/90 дугаартай тушаалыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр хүчингүй болгосугай.” гэсэн нь 2022 оны Б/90 тушаалыг гарсан цагаасаа хүчингүй гэсэн агуулгаар ойлгох нөхцөлийг бүрдүүлсэн байх тул В.Лут-Очирт ажил хавсран гүйцэтгэсний 20 хувийн нэмэгдлийг олгосон бол буцаан гаргуулахаар зохицуулалтыг агуулсан байна. Түүнчлэн ажил хавсарган гүйцэтгүүлэх гэсэн нэршил байхгүй болно;

- “Ж.Бат-Ирээдүйгийн хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай” 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Б/162 дугаар тушаалын үндэслэх хэсэгт хөдөлмөрийн ноцтой зөрчил гаргасан ажилтантай байгуулсан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах зохицуулалтыг үндэслэсэн байх тул захирамжлах хэсэгт ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулж, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгохоор байна. Тушаалын агуулга, найруулга алдаатай.

Ажилтны цалин хөлсийг тогтоохтой холбоотой зөрчлүүд:

“И-Монгол академи” УТҮГ-ын албан тушаалын цалингийн сүлжээг захирлын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар баталсан байх бөгөөд тушаалын 2 дугаар хавсралтаар Систем хөгжүүлэлтийн хэлтэс, Ашиглалт үйлчилгээний албаны ажилтны мэргэжлийн ур чадварыг харгалзан цалингийн шатлалыг 1-3 дугаар түвшинд ангилж, түвшин тогтоох журамтай байхаар заасан ч тусгайлсан журам батлахгүйгээр ажилтны цалинг өөр өөрөөр тогтоосон бөгөөд И-Монгол академи УТҮГ-ын захирлын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгууллагын ажилчдын цалингийн сүлжээг шинэчлэн баталж, дээрх 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Б/01 дүгээр тушаалыг хүчингүй болгосон байна.

Түүнчлэн Систем хөгжүүлэлтийн хэлтэс, Ашиглалт үйлчилгээний албаны ажилтны албан хаагчдын түвшинг тогтоохдоо ур чадвар, ажилласан жилийг харгалзахаар, ажилтан мэргэжлийн өндөр ур чадвартай, тухайн ажлыг цаашид бие даан гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвар эзэмшсэн гэж үзсэн тохиолдолд

ажилласан жил харгалзахгүйгээр цалингийн хэмжээг тогтоох талаар тушаалын хавсралтад тайлбар хийж, 0-2 жил ажилласан бол албан тушаалын I түвшин, 2-5 жил ажилласан бол албан тушаалын II түвшин, 5-аас дээш жил ажилласан бол албан тушаалын III түвшинд хамааруулан цалинг тогтоосон байна. Дээрх тушаалыг үндэслэж 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/132 дугаар, Б/133 дугаар тушаалаар нэр бүхий албан тушаалд ажиллагсдын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

Түүнчлэн дотоод журам болон цалин хөлсийг зохицуулсан дотоод журмаар ажилтныг томилох хугацааны талаар зохицуулаагүй байх тул ажилтныг үндсэн ажилтан болгох, туршилтаар болон дагалднаар томилох үндэслэл тодорхой биш захирлын үзэмжээр, ялгаатай байдлаар тушаал шийдвэрүүд гаргаж, цалин хөлсийг ялгаатай байдлаар тогтоосон байна.

4.Архив, албан хэрэг хөтлөлт

“И-Монгол академи” УТҮГ-ын 2022 оны архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд байгууллагад ирсэн бичгийн 4 боть, байгууллагаас явсан бичгийн 4 боть, бусад нэгжүүдээс архивт хүлээлгэж өгсөн 36 боть баримт, бүртгэлийн 2 дэвтрийн хөтлөлт, архив, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж байгаа тэмдэг, дардас, архивын зориулалтаар ашиглаж байгаа өрөөтэй танилцлаа.

Байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг захирлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/90 дугаартай тушаалаар байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталсан байна.

Илэрсэн зөрчил:

“И-Монгол академи” УТҮГ-ын үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан албан бичиг, бусад байгууллагаас ирүүлсэн албан бичгийн хөтлөлтөд хяналт шалгалтын ажлыг хийхэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 2.2.1.3, 2.2.1.4, 3.1.5-д заасны дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлтөд ашиглах индекс батлуулаагүй, бичгийн дугаарлалт өөр өөр, журмын 4.2.5, 4.2.6-д заасны дагуу албан бичгийн хөл дардасны орон дутуу, 5.4-т заасны дагуу байгууллагад ирсэн бичгийн бүртгэл дээр шилжүүлсэн албан хаагчийн мэдээлэл бичдэггүй, бүрдэл дутуу, Стандарт, хэмжил зүйн газрын “Баримт бичгийн стандартын эмхэтгэл/MNS 5140-2:2021/-ийн 5.21, 5.23, 5.28-д заасны дагуу албан бичигт ашиглагддаг дардас, тэмдгүүд стандартад заасан хэмжээтэй биш, “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 6.6-д заасны дагуу тамга, тэмдэг түших албан хаагч дээр тусгайлан удирдах албан тушаалтны тушаал гаргаагүй, архивын зориулалтаар ашиглах өрөө тасалгаа стандартын шаардлага хангаагүй байна.

Дөрөв.Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

“И-Монгол академи” УТҮГ-ын салбарын бодлого, төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын ажлыг үндэслэн дүгнэлт гаргаж, чиглэл тус бүрд дараах зөвлөмжийг хүргүүлж байна:

1.Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас өгсөн чиглэлийн хэрэгжилтийн хүрээнд:

-Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас өгсөн бүх үүрэг, чиглэлийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн, шийдвэрлэлтийн талаар эргэж мэдээлдэг байх;

-Үндсэн болон дэмжих системтэй холбоотой тайланг "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-д заасан хугацаанд тайлагнаж хэвших;

-Албан бичгийг шийдвэрлэхдээ үнэн зөв, тодорхой бичиж хааж байх;

-Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанарын менежментийн тогтолцоо болон бусад стандартуудыг нэвтрүүлэх;

-“Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам”-ын дагуу мэдээлэл хариуцагчид хүргүүлэх зөвлөмж, дүгнэлтийн тайланг ажлын 5 хоногт багтаан тус яаманд ирүүлж байх;

-Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хариуцан ажиллаж байгаа систем, программ хангамжийн холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллах;

-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд цахим хэлбэрээр харилцахдаа албаны цахим шуудан болон энэ хуулийн 21, 23, 24 дүгээр зүйлд заасан дэмжих системийг ашиглана гэж заасны дагуу албан хариуг хүргүүлэхдээ албаны цахим шуудан эсвэл дэмжих систем ашиглах;

-Системүүдийн нэгдсэн хяналтын самбар /dashboard/-ыг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэх;

- Системүүдийн нэгдсэн хяналтын самбарыг хөгжүүлэх хүртэл хугацаанд тус яаманд 7 хоног бүр ирүүлдэг тайлангийн загварыг боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулах, мөрдөж ажиллах;

-“И-Монгол академи” УТҮГ-ын чиг үүрэгт хамаарах дэмжих болон бусад системийг “Үндэсний дата төв” УТҮГ-аас хүлээн авах ажлыг яаралтай зохион байгуулж, цаашдын найдвартай, тасралтгүй байдлыг хангаж ажиллах.

2.Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулсан болон албан хаагчдаас гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хүрээнд:

-Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг тодорхой бичиж, бүрэн хөтлөх;

-Тус байгууллагын info@ema.gov.mn болон system@ema.gov.mn цахим хаягт ирүүлсэн өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу бүртгэн, холбогдох ажиллагааг хийх;

-Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн 2 дугаар шугамын тусгай дугаараар хүлээн авч байгаа гомдлын дуудлагыг хадгалж, гомдлын агуулгыг бүрэн шивж оруулах;

-system@ema.gov.mn цахим хаягт ирүүлсэн өргөдөл, гомдлыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу тогтоосон хугацаанд багтан шийдвэрлэж, өргөдөл, гомдол гаргагчид хариу мэдэгдэх;

-Өргөдөл, гомдлын явц, шийдвэрлэлтийг бүрэн тайлагнаж, Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн цахим хуудсаар дамжуулан өөрийн гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлын процесс, шийдвэрлэлттэй танилцах боломжийг бүрдүүлэх;

-“Иргэд, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааны журам”-д хэрэглэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан тусгаж өгөх;

-“И-Монгол академи” УТҮГ-ын захирлын А/60 дугаар тушаалаар баталсан “Иргэд, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааны журам”-ын зургаа дугаар хэсэгт заасан Үйлчилгээний стандартыг операторуудын байнгын үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэвшүүлэх, операторуудыг чадавхжуулах ажлыг тогтмол хийж байх.

3.Хүний нөөцийн чиглэлээр 2022-2023 онд гаргасан захирлын тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, боловсруулалтын хүрээнд:

-Хүний нөөцийн чиглэлээр гарч байгаа тушаал шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад журмын оновчтой зохицуулалтыг үндэслэх;

-Захирамжлалын баримт бичгийн стандартын дагуу Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журмыг мөрдлөг болгон утга агуулга, хэлбэрийн, үг үсгийн алдаагүй тушаал шийдвэр гаргах;

-Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.1.1-т цалингийн жишиг, үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалин хөлс тогтоох зарчим болон эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд үндэслэн захирал тогтоох”-оор заасан тул Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал”, 06 дугаар тогтоолоор баталсан “Цалин хөлс тогтоох аргачлал”-ыг тус тус баримтлан цалингийн сүлжээг батлах;

-Зөрчилтэй тушаал, шийдвэрийн зөрчлийг арилгах;

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд:

-Байгууллагын баримт бичгийг боловсруулахад Монгол улсад мөрдөгдөж буй Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага стандартыг мөрдлөг болгох;

-Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, 2016 оны Архивын ерөнхий газрын даргын нэмэлт өөрчлөлт оруулсан Байгууллагын архивын ажлын үндсэн заавар, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт хэмжил зүйн газрын Баримт бичгийн стандартын эмхэтгэл MNS5140-1:2021, MNS5140-2:2021, MNS5140-3:2021 зэрэг эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллах;

-Архивын зориулалтаар ашиглах өрөө тасалгааны стандартыг хангах.